



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/В

Пионер толгой

Хязгаарлалтын дэглэмд шилжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Давааны ам 2 дугаар багийн нутаг Үнэгтийн өвөрт гарсан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний халдварыг таслан зогсоох, голомтыг устгах, халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон “Хорио цээрийн дэглэм”-ийг цуцалж 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 01 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний үед мөрдөгдөж байгаа хязгаарлалтын дэглэмийг баримтлан, хяналтын постонд гарч байгаа албан хаагчдийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Тамгын газрын дарга (Р.Гантулга)-д, шүлхий өвчний хариу арга хэмжээг эрчимжүүлэх, хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлэх, халдварын шинэ голомт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Хас-Очир), “Хөгжил дэвшил нэгдэл” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч (Б.Бат-Эрдэнэ), багийн Засаг дарга (Д.Мөнхчулуун) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



64 101111